НУТАГ КОНСАЛТИНГ ХХК-ИЙН ЗАХИРАЛ
Н.ШИНЭБОЛД ТАНАА

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ
Нийслэлийн Засаг захиргааны III байр,
Ж.Самбуугийн гудамж, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: (976) 7799 0101
Цахим шуудан: ubhd@emg.ub.gov.mn
Цахим хуудас: www.ubhealth.mn

2025.04.25 № 10-13-02/021/972

Зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийсэн тухай

Тус газарт ирүүлсэн хүсэлтийн дагуу Монгол Улсын Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрмийн 4.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн яамны салбарын хяналтын газрын даргын баталсан Барилга байгууламжийн зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг өөрчлөхөд эрүүл ахуйн хяналт шалгалт хийх тухай 10-00/01 дугаартай удирдамжийг үндэслэн 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн өргөтгөлийн барилгын зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийлээ.

Зураг төсөл боловсруулсан байгууллагын нэр, зураг төслийн нэр, үе шат

Нийслэлийн ерөнхий архитекторын бүтээд Хот байгуулалт, хөгжлийн газрын даргын баталсан 2022 оны МЗХ2022/14-010 дугаар бүхий архитектур төлөвлөлтийн даалгавартай,

Нутаг консалтинг ХХК-ийн боловсруулсан 2024 онд батлагдсан загвар зурагтай. Сүхбаатар дүүргийн тамгын газрын даргын 2024 оны 08 дугаартай зураг, төсөв боловсруулах даалгавартай.

Ерөнхий төлөвлөгөө, барилга архитектур, барилга бүтээц, цэвэр, бохир усны ажлын зургийг Нутаг консалтинг ХХК-д 2025 онд боловсруулсан. ЕТ,БА- зургийн шифр НК-27/24.

Барилга байгууламж барих газрын зөвшөөрөл:

Сүхбаатар дүүргийн ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд тус дүүргийн 01 дүгээр хороонд сургалтын зориулалтаар 6826 м.кв газрыг 15 жилийн хугацаатай олгосон төрийн байгууллагын 000438595 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээтэй.

Барилгын давхрын байгуулалт:

Сүхбаатар дүүргийн ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн тус өргөтгөлийн барилга нь зоорьтой 3 давхар төмөр бетонон карказ бүтээцтэй.

Зоорийн давхарт коридор, шатны хонгил, 20.49-34.59 м.кв хүнсний 2 агуулах, 70.41 м.кв агуулах, 26.69 м.кв аж ахуйн өрөө, үйлчлэгчийн өрөө,цахилгаан, дулааны техникийн өрөөтэй байхаар төлөвлөгдсөн,

1550082144

1 дүгээр давхарт гонх, шат, шатны хонгил, вестибюль, гадагш хаалгатай, шүршүүр, ариун цэврийн өрөө бүхий ажилчдын хувцас солих өрөө, 20.4-20.9 м.кв 2 бэлтгэлийн өрөө, 9.6-29.52 м.кв талбайтай 3 халуун боловсруулалтын өрөө,14.61 м.кв угаалгын өрөөтэй байхаар төлөвлөсөн;

2 дугаар давхарт шатны хонгил, коридор, 15.28-16.86 м.кв талбайтай 2 албан өрөө, 155.43 м.кв танхим, 29.79 м.кв хооллох хэсэг, 15.61 буфет хэсэг, эрэгтэй эмэгтэй ариун цэврийн өрөөтэй байхаар төлөвлөсөн;

3 дугаар давхарт шатны хонгил, коридор, эрэгтэй, эмэгтэй сурагчдын хувцас солих өрөө, тоног төхөөрөмжийн өрөө, 226.7 м.кв гимнастикийн заал, ариун цэврийн өрөөтэй байхаар төлөвлөсөн байна.

Барилгын халаалт, агаар сэлгэлт: Барилгын зоорийн давхарт механик систем, бусад өрөөнд ердийн, гал тогоо, гимнастикийн танхимд агаар оруулах, сорох механик төхөөрөмжтэй байхаар төлөвлөсөн байна.

NETCOM Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2024 оны B-U-2024/850 дугаартай техникийн нөхцөлтэй.

Ус хангамж. УСУГ-ын 2024 оны 797/24 дугаартай техникийн нөхцөлтэй.

Цахилгаан хангамж: УБЦТС ТӨХК-н 2025 оны 01/00232/25 дугаартай техникийн нөхцөлтэй.

Дулаан хангамж: УБДС ТӨХК-н 2024 оны 576/2024 дугаартай техникийн нөхцөлтэй.

Энх-Өрнөлт ХХК-д 2018 онд хийсэн инженер геологийн судалгаагаар асгамал хөрс зузаан тархсан, хөрсний ус 4.7м-ийн гүнд илэрсэн зэргээс дунд зэргийн нөхцөлтэй. ЗТ//-266/16

Монгол Улсын Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалтыг үндэслэн ДҮГНЭХ НЬ: Барилгын зураг төслийн Нутаг консалтинг ХХК-ийн боловсруулсан Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн орогтолийн барилгын ажлын зураг төсөл, холбогдох бичиг баримтад урьдчилсан хяналт хийжод Монгол Улсын Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт БНбД 31-25-22 норм ба дүрмийн эрүүл ахуйн холбогдох шаардлагад нийцэж байна.

Улсын байцаагчийн гаргасан дүгнэлтийг үндэслэлгүй гэж үзвэл Монгол улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалтыг үндэслэн гомдол гаргах эрхтэй.

ЭРҮҮЛ АХУЙ ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ М.НЭРГҮЙ

ХҮЛЭЭН АВСАН.
ЗАХИРАЛ Н.ШИНЭБОЛД

Дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй бол тайлбар тэмдэглэл .....

Улсын байцаагчийн тэмдэглэл.....

НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР
ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МАГАДЛАЛ ХИЙСЭН ТУХАЙ
ДҮГНЭЛТ

2025 оны 04 сарын 01 өдөр Дугаар 009/96 Улаанбаатар хот

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ

Нэг. Барилга байгууламжийн зураг төслийн мэдээлэл

1. Барилга байгууламжийн байршил: Сүхбаатар дүүргийн 1-р хороо
2. Архитектур төлөвлөлтийн даалгавар: 2022.05.05-ны МЗХ2022/14-010
3. Зургийн шифр, зураг төслийн компани: НК-27/24 "Нутаг консалтинг" ХХК
4. Барилга байгууламжийн зориулалт: 1-р сургуулийн өргөтгөлийн барилга
5. Барилгын давхар, талбай, эзлэхүүн: 3 давхар /зоорьтой/, V = 3949.98 м^3
6. Галд тэсвэршилтийн зэрэг: төлөвлөсөн: II
7. Барилгын үүргийн галын аюулын анги: Ф4.1
8. Зургийн иж бүрдэл 1 хэсэг.

Хоёр. Дүгнэлт

№000438595 Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2015 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/454 тоот шийдвэрийг үндэслэн, нэгж талбарын 18642310889803 дугаар бүхий 6826 м.кв /га/ газрыг 15 жилийн хугацаатай Сүхбаатар дүүргийн 1-р хороонд байрлах Сургалт зориулалтаар олгосон газрыг үндэслэн газарт барих барилгын ажлын зурагт хяналт хийхэд:

1. Галын дохиоллын систем төлөвлөж байрлуулан системийн тооцоог шалгуулах, галын дохиоллын хүлээн авагч станцыг 24 цагаар байрлах өрөө тасалгаанд байрлуулах.
2. Гал тэсвэршилтийн I-III зэрэглэлийн барилгын гадна ханын гадаргууг шатдаг, тэсвэрлэн шатдаг материалаар өнгөлөхийг зөвшөөрөхгүй. /БНбД 21-01-02/-ийн 2.8, Барилгын гадна ханын дулаалгад галд шатдаггүй материал сонгож төлөвлөх /материалын шинжилгээний дүгнэлтийг хавсаргах/
3. Барилга баригдах байршилд барилга хоорондын галаас хамгаалах зай хэмжээг БНбД 30-01-04 дүрмийн заавал биелүүлэх 4 дүгээр хавсралтын дагуу хийж гүйцэтгэх.

4. Аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжид зайлшгүй байх шаардлагатай гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг байрлуулах /MNS5566:2020/ стандартын дагуу үйлчилгээ явуулдаг өрөө тасалгаанд гал унтраагуул байрлуулж, галын аюулаас урьдчилан сэргийлэх санамж, анхааруулга, аврах гарцын тэмдэг тэмдэглэгээ бичиж байрлуулах.

Дээрх шаардлагыг биелүүлснээр тус ажлын зураг нь галын аюулгүй байдлын шаардлагыг хангаж байгаа болно. /Ажлын зураг дээр зөвшилцөн засаж, нормын дагуу засвар хийгдсэн зургаар барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн байх шаардлагатай/

Барилга эхлэхээс өмнө зураг төсөлд өөрчлөлт оруулах тохиолдолд Онцгой байдлын байгууллагатай зөвшилцөж шийдвэрлэнэ.

Хянасан сар, өдөр	Тэмдэг дарсан хуудасны дугаарууд	Нэмэлт тэмдэглэл
2025.04.01	Нүүр хуудас БА 02 03 04 05 06 ЦБУ 04 05 06 07 ХД 8 10 12 14	Архитектур төлөвлөлтийн даалгаврын дагуу хийж гүйцэтгэх

БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСЛИЙН ХЯНАЛТЫН АХЛАХ БАЙЦААГЧ,
ХОШУУЧ Б.ДАВААСҮРЭН